



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2025/093/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ард. 02.24 № 145
танай ард. 01.24 -ны № 10 -т

Г ДОРНОД АЙМГИЙН МУЗЕЙН
ЗАХИРАЛ В.НАРАНГЭРЭЛ ТАНАА

Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Музейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын өөрийн ажилтнаар нэхэмжлэх шивүүлж нийт 17,230.9 сая төгрөгийн зарлагын шилжүүлэг хийсэн, Ажилтанд удаан жил ажилласан нэмэгдлийг 549.5 мянган төгрөгөөр дутуу тооцон олгосон, байгууллагын эргэлтийн хөрөнгө 7,125.0 мянган төгрөгийн мал амьтдыг данснаас хасахдаа акт үйлдээгүй, бараа материалд 25,758.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6-д Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.4-т Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн

011022137

байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Дорнод аймгийн Музейн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилго, 20 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 85.1 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,950,576.33	85,711,779.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,803,897.33	5,780,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,803,897.33	5,780,000.00
3121	Төгрөг	9,803,897.33	5,780,000.00
31211	Төрийн сангийн харилцах	803,897.33	-
31218	Ахмадын сангийн харилцах	9,000,000.00	5,780,000.00
33	АВЛАГА	-	6,000,000.00
335	Бусад авлага	-	6,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	6,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,146,679.00	73,931,779.00
354	Хангамжийн материал	64,021,679.00	73,931,779.00
35410	Бичиг хэргийн материал	1,634,052.00	8,201,152.00
35420	Аж ахуйн материал	19,130,137.00	19,152,137.00
35430	Сэлбэг хэрэгсэл	495,950.00	914,950.00
35470	Бусад хангамжийн материал	42,761,540.00	45,663,540.00
35600	Мал амьтад	7,125,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,780,222,908.87	1,764,818,222.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,780,222,908.87	1,764,818,222.59
392	Биет хөрөнгө	1,045,097,908.87	1,030,068,222.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	255,536,016.94	255,536,016.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	(157,006,461.45)	(190,926,777.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,790,757.75	112,431,757.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,261,083.91)	(64,995,532.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,951,172.00	33,951,172.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,400,705.64)	(29,525,137.24)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	884,033,840.00	890,893,840.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,711,180.00	68,711,180.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(44,256,806.82)	(46,008,296.70)
393	Биет бус хөрөнгө	735,125,000.00	734,750,000.00
39301	Програм хангамж	1,910,000.00	1,910,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(785,000.00)	(1,160,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	734,000,000.00	734,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,861,173,485.20	1,850,530,001.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,250,900.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,250,900.00
413	Өглөг	-	4,250,900.00
4136	Бусад өглөг	-	4,250,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	4,250,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,861,173,485.20	1,846,279,101.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,861,173,485.20	1,846,279,101.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,821,503,992.00	1,821,503,992.00
51101	Өмч: - төрийн	1,821,503,992.00	1,821,503,992.00
512	Хуримтлагдсан үр дүн	(156,477,537.74)	(171,371,921.35)
51210	Өмнөх үеийн үр дүн	(150,065,517.61)	(156,477,537.74)
51220	Тайланг үеийн үр дүн	(6,412,020.13)	(14,894,383.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,147,030.94	196,147,030.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,861,173,485.20	1,850,530,001.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	547,591,345.28	727,327,084.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,752,410.00	47,914,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	55,752,410.00	47,914,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,000,410.00	41,054,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,000,410.00	40,635,950.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	419,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,577,000.00	6,860,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,175,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	491,838,935.28	679,412,134.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	474,535,056.00	634,664,134.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,535,056.00	634,664,134.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	39,748,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39,748,000.00
1330	Төсвийн захирагчдаас	17,303,879.28	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,303,879.28	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	559,008,365.41	742,221,467.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	559,008,365.41	742,221,467.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503,843,697.41	712,300,222.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,298,783.58	497,650,226.48
210101	Үндсэн цалин	238,196,019.14	314,187,334.13
210102	Нэмэгдэл	56,331,763.23	110,922,221.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,213,992.90	32,631,886.42
210104	Урамшуулал	27,557,008.31	39,908,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,393,798.00	59,978,802.75
210201	Тэтгэврийн даатгал	31,125,705.00	40,785,656.75
210202	Тэтгэмжийн даатгал	3,640,926.00	4,847,673.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,829,784.00	2,488,296.00
210204	Ажилгүйдлийн даатгал	646,975.00	2,260,401.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,150,408.00	9,596,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	31,717,829.27
210301	Гэрэл, цахилгаан	-	14,001,829.27
210302	Түлш, халаалт	-	16,216,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,739,520.00	11,133,520.00
210401	Бичиг хэрэг	1,999,220.00	3,086,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	3,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,300.00	2,446,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	550,000.00	10,743,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,743,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550,000.00	-
210604	Урсгал засвар	-	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,211,400.00	9,690,800.00
210702	Дотоод албан томилолт	2,211,400.00	9,690,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,861,960.00	20,295,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,167,737.00	14,379,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	980,000.00
210807	Газрын төлбөр	4,974,223.00	4,935,878.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,788,235.83	71,090,566.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,322,700.00	25,184,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,465,535.83	45,905,686.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,164,668.00	29,921,244.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,164,668.00	18,545,250.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	13,665,250.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,553,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлдэг дэмжлэг	38,886,668.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	725,000.00	4,880,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,345,824.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,345,824.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	-	30,170.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	30,170.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11,417,020.13)	(14,894,383.61)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,995,000.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	3,995,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,995,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,412,020.13)	(14,894,383.61)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	525,839,345.28	720,048,084.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,000,410.00	40,635,950.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,000,410.00	40,635,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,000,410.00	40,635,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,000,410.00	40,635,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	491,838,935.28	679,412,134.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	474,535,056.00	634,664,134.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,535,056.00	634,664,134.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	39,748,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39,748,000.00
1330	Төсвийн захирагчдаас	17,303,879.28	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,303,879.28	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	525,875,319.58	724,071,981.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,875,319.58	724,071,981.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,710,651.58	701,275,736.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,298,783.58	497,650,226.48
210101	Үндсэн цалин	238,196,019.14	314,187,334.13
210102	Нэмэгдэл	56,331,763.23	110,922,221.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,213,992.90	32,631,886.42
210104	Урамшуулал	27,557,008.31	39,908,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,393,798.00	59,978,802.75
210201	Тэтгэврийн даатгал	31,125,705.00	40,785,656.75
210202	Тэтгэмжийн даатгал	3,640,926.00	4,847,673.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,829,784.00	2,488,296.00
210204	Ажилгүйдлийн даатгал	646,975.00	2,260,401.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,150,408.00	9,596,776.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	31,717,829.27
210301	Гэрэл, цахилгаан	-	14,001,829.27
210302	Түлш, халаалт	-	16,216,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,239,510.00	10,720,620.00
210401	Бичиг хэрэг	2,499,210.00	2,674,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	3,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,300.00	2,446,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,821,600.00	35,632,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,921,600.00	27,632,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	900,000.00	-
210604	Урсгал засвар	-	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,211,400.00	9,690,800.00
210702	Догоод албан томилолт	2,211,400.00	9,690,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,861,960.00	31,439,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,167,737.00	25,524,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	540,000.00	980,000.00
210807	Газрын төлбөр	4,974,223.00	4,935,878.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,883,600.00	24,444,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,883,600.00	24,444,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,164,668.00	22,796,244.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,164,668.00	11,420,250.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,540,250.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,553,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,886,668.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	725,000.00	4,880,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,345,824.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,345,824.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	30,170.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	30,170.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(35,974.30)	(4,023,897.33)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(35,974.30)	(4,023,897.33)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	839,871.63	9,803,897.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	803,897.33	5,780,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(150,065,517.61)	1,867,585,505.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(150,065,517.61)	1,867,585,505.33
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	(15,412,020.13)	(15,412,020.13)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(165,477,537.74)	1,852,173,485.20
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(165,477,537.74)	1,852,173,485.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(165,477,537.74)	1,852,173,485.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	(14,894,383.61)	(14,894,383.61)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,821,503,992.00	196,147,030.94	(180,371,921.35)	1,837,279,101.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		803,897.33
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	689,810,200.00	679,758,157.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	689,810,200.00	679,758,157.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,751,950.00	668,337,907.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,653,700.00	497,650,226.48
210101	Үндсэн цалин	315,525,000.00	314,187,334.13
210102	Нэмэгдэл	116,679,900.00	110,922,221.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,216,000.00	32,631,886.42
210104	Урамшуулал	41,232,800.00	39,908,784.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,206,800.00	59,978,802.75
210201	Тэтгэврийн даатгал	42,300,600.00	40,785,656.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,976,500.00	4,847,673.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,488,300.00	2,488,296.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,488,300.00	2,260,401.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,953,100.00	9,596,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,900,000.00	10,720,620.00
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	2,674,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,800,000.00	3,800,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	2,500,000.00	2,446,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,682,700.00	27,632,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,682,700.00	27,632,500.00
2107	Томилолт, зочны зардал	11,969,150.00	9,690,800.00
210702	Дотоод албан томилолт	11,969,150.00	9,690,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй зардал	30,302,200.00	31,439,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	23,275,500.00	25,524,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,420,000.00	980,000.00
210807	Газрын төлбөр	5,006,700.00	4,935,878.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,037,400.00	31,224,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,037,400.00	21,224,980.00
	Эрдэм шинжилгээ судалгаа	10,000,000.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,058,250.00	11,420,250.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,058,250.00	11,420,250.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,540,250.00	6,540,250.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төлбөр, үзүүлэх лэмжлэг	7,638,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,880,000.00	4,880,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	689,810,200.00	684,734,259.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	649,174,250.00	643,294,412.57
131001	Улсын төсвөөс санхүүжих	644,174,250.00	638,294,412.57
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	5,000,000.00	5,000,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	40,635,950.00	40,635,950.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	40,635,950.00	40,635,950.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	803,897.33
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,780,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	Үйлчлэх ажилтан	12	12
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	12	12
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,748,000.00	39,717,829.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,748,000.00	39,717,829.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,748,000.00	39,717,829.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,748,000.00	31,717,829.27
210301	Гэрэл, цахилгаан	17,248,000.00	14,001,829.27
210302	Түлш, халаалт	13,000,000.00	16,216,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,748,000.00	39,717,829.27
1311	Санхүүжилтийн орлого	39,748,000.00	39,717,829.27
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,748,000.00	39,717,829.27
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 57.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 57.7 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайланг улсын төсөв, орон нутгийн төсвөөр тусдаа 39.7 сая төгрөгөөр санхүүгийн тайлан бэлтгэсэн байгааг нэгтгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- НУХУС ПАБЛИШН ХХК-тай зурагт тайлбар бүтээл хийлгэх 9.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба тайлант онд төлбөрийн урьдчилгааг 5.0 сая төгрөг төлсөн үлдэгдлийг 2025 онд төлөх учир өр төлбөрөөр бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгалийн түүхийн музейтэй хамтарч үзмэр дэглэлтийн ажлыг Музейн сэргээн засварлагчтай 6.0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч 2025.02.09-ны дотор тус ажлыг зохион байгуулах учир шилжүүлсэн төлбөрийг авлагаар бүртгэж залруулав. УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үзмэрийн үйлчилгээний ажилчдад хийлгэсэн хувцсыг шууд зардалд бүртгэснийг буцаан орлого авч эд хариуцагчийн картад бүртгүүлэв, Аймгийн "Өв соёлын дээжис" каталог хийлгэснийг бараа материалд орлого болгож нийт 7.3 сая төгрөгийн хөрөнгийг залруулав. УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Бараа материалын тооллогын биет горим хэрэгжүүлэхэд бүртгэл дутуу тусгасан 0.4 сая төгрөгийн хөрөнгүүдийг орлого болгож залруулав. УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 57.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 3.0 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 43.2 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 4.4 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

2.1 Төлбөрийн акт

1. Ажилчдын удаан жил ажилласан нэмэгдлийг дутуу тооцоолон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Байгууллагын удирдлагад Аймгийн засаг даргын 2024.12.18-ны Б/58 дугаар захирамжаар шагнал, урамшууллыг 100 хувь, Аймгийн засаг даргын 2024.12.24-ны Б./67 дугаар захирамжаар 150 хувиар давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Албан шаардлага

1. Нийт 6 ажилтнаас и-баримтын нэхэмжлэх шивүүлж нийт 17.2 сая төгрөгийн шилжүүлэг хийсэн ба тус зардлуудтай холбогдох анхан шатны баримт хавсаргаагүй, худалдан авсан 14.3 сая төгрөгийн хөрөнгөд худалдах худалдан авах гэрээ хийгээгүй, тухайн хөрөнгийн дагалдах бичиг баримтыг бүрдүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “Анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.1.2-т Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Албан хаагчдад олгох тэтгэмжийн тушаалын хавсралтад нэр байхгүй байхад 2 удаа олгож залруулга хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-т “..., гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн нийцэхгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Байгууллагын бүртгэл дэх бүх мал амьтадыг зүдэд өртөж данснаас хасахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр, актыг үйлдээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
4. Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх гэсэн заалтууд болон үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Байгууллагын удирдлагад Аймгийн засаг даргын 2024.12.18-ны Б/58 дугаар захирамжаар шагнал, урамшууллыг 100 хувь, Аймгийн засаг даргын 2024.12.24-ны Б./67 дугаар захирамжаар 150 хувиар давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно 15.1.3 Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэж заасныг зөрчсөн, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй бүртгэл мэдээллийн санчийн программ, хуучин санхүүгийн программыг данснаас хасаагүй 4.4 сая төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь УСНББОУС 01, нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй бүртгэлийн болон санхүүгийн программыг дээд шатны байгууллагын шийдвэрийг үндэслэн .

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланг улсын төсөв, орон нутгийн төсвөөр тусдаа 39.7 сая төгрөгөөр санхүүгийн тайлан бэлтгэсэн байгааг нэгтгэв	1	39,717.8					1	39,717.8				
Зурагт тайлбар бүтээл хийлгэх 9.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба тайлант онд төлбөрийн урьдчилгааг 5.0 сая төгрөг төлсөн үлдэгдлийг 2025 онд төлөх учир өр төлбөрөөр бүртгэсэн	1	4,250.9					1	4,250.9				
Байгалийн түүхийн музейтэй хамтарч үзмэр дэглэлтийн ажлыг Музейн сэргээн засварлагчтай 6.0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч 2025.02.09-ны дотор тус ажлыг зохион байгуулах учир шилжүүлсэн төлбөрийг авлагаар бүртгэсэн	1	6,000.0					1	6,000.0				
Үзмэрийн үйлчилгээний ажилчдад хийлгэсэн хувцсыг шууд зардалд бүртгэснийг буцаан орлого авч эд хариуцагчийн картад бүртгүүлэв	1	7,347.0					1	7,347.0				
Бараа материалын тооллогын биет горим хэрэгжүүлэхэд бүртгэл дутуу тусгасан хөрөнгүүдийг орлого болгож залруулав.	1	419.0					1	419.0				
Дүн	5	57,734.7					5	57,734.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийт 6 ажилтнаас и-баримтын нэхэмжлэх шивүүлж нийт 17.2 сая төгрөгийн шилжүүлэг хийсэн ба тус зардлуудтай холбогдох анхан шатны баримт хавсаргаагүй, худалдан авсан	1	17,230.9			1	17,230.9						
Албан хаагчдад олгох тэтгэмжийн тушаалын хавсралтад нэр байхгүй байхад 2 удаа олгож залруулга хийсэн	1	549.4	1	549.4								

Байгууллагын бүртгэл дэх бүх мал амьтадыг зурдад өртөж данснаас хасахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр, актыг үйлдээгүй	1	194.6			1	194.6					
Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэсэн	1	7,125.0			1	7,125.0					
Байгууллагын удирдлагад Аймгийн засаг даргын 2024.12.18-ны Б/58 дугаар захирамжаар шагнал, урамшууллыг 100 хувь, Аймгийн засаг даргын 2024.12.24-ны Б./67 дугаар захирамжаар 150 хувиар давхардуулан олгосон	1	25,758.0			1	25,758.0					
Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй бүртгэл мэдээллийн санчийн программ, хуучин санхүүгийн программыг данснаас хасаагүй	1	4,410.0					1	4,410.0			
Дүн	5	57,699.5					5	57,699.5			



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 43/19128799
дха - 2025/093/HA-CTA-TUB

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус Музейн ажиллагсадын төрд алба хаасан хугацааны нэмэгдлийг 549,489.62 төгрөгөөр дутуу тооцон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Монгол улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам" -ын шаардлагыг хангаагүй болон дутуу тооцон олгосон 549,489.62 /таван зуун дөчин есөн мянга дөрвөн зуун наян есөн төгрөг жаран хоёр / мөнгийг ажилтан Б.Булгантамир, М.Цэрэнсодном нарт нөхөн олгох

2125050200

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 42/19125799
ДДА - 2025/1043/НА-СТА-ТМБ

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын удирдлагад 2,431,500.00 төгрөгийн нэмэгдэл урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын мөрдөөгүй давхардуулан олгосон урамшуулал 2,431,500.00 /хоёр сая дөрвөн зуун гучин нэгэн мянга таван зуун/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2125050199

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

144076
ХТ 17 9230891



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 121/19165799
2025/043/НА-СТА-ТМБ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийн жагсаалтаар батлагдаагүй ажилтанд 194,640.00 төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.3.6 дахь "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрээр ажил гүйлгээг хийх, жагсаалтаар батлагдаагүй ажилтанд урамшуулал олгохгүй байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040246

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллахыг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 100/19125799
00А-2025/093/НН-СТА-НЦБ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй мал амьтдыг эрх бүхий албан тушаалтын шийдвэр, мал амьтдын тооллогын бүртгэл, анхан шатны баримтгүй 7,125,000.00 төгрөгөөр данснаас хассан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 20.2-т "Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д "20.2.Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2 дох "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрээр мал амьтдыг бүртгэлээс хасах, тооллого бүртгэлийг хийж баримтаар баталгаажуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040249

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллахыг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар НББ/1912.5799
АВА-2025/093/НА-СТА-ТМ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн шалгуур хангасан хөрөнгийг бараа материал дансанд 25,758,000.00 төгрөгөөр бүртгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт “Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журам” -ын 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх”; 4.2.1-д “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харъяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.1 дэх “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”, 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалд бүртгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэх, НББОУС 16 -г даган мөрдөх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллахыг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт даалгав.

2125040252

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 120/199125799
ДДА-2025-043/НА-СТА-Т263

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Музейн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материал худалдан авсан 17,230,900.00 төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, худалдан авах гэрээ байгуулаагүй тоног төхөөрөмжийг дагалдах анхан шатны бичиг баримтгүй хүлээн авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" зарчим, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.2-т Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба нийцсэн байх батламж мэдэгдэл" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 дэх "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил гүйлгээг анхан шатны баримтын иж бүрдлийг ханган бүртгэх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040243

2. Холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөн ажиллахыг Дорнод аймгийн Музейн захирал В.Нарангэрэл, нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

